



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ц.МӨНХТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.09 № 108/763  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуулгын хариу хүргүүлэх  
тухай

Танаас 2026 оны 10 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуульд туссан болон 2027 оны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгахаар төлөвлөж буй төрийн албан хаагчдын цалингийн мэдээллийн талаарх асуулгын хариуг Танд үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгааг хангах чиглэлээр жил бүр тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, 2023 онд төрийн албан хаагчдын үндсэн цалинг дунджаар 40 хувиар, 2024 онд 10-20 хувиар, 2025 онд 6 хувиар тус тус нэмэгдүүлэн тогтоосон.

Түүнчлэн, хөдөө, орон нутагт төрийн албан хаагчдыг тогтвор, суурьшилтай ажиллуулах, төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд 2024 оноос эхлэн хөдөөгийн суманд ажиллаж байгаа 51.8 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 40 хувь, харин аймгийн төвийн сум болон нийслэлийн алслагдсан гурван дүүрэгт ажиллаж байгаа 53.4 мянган төрийн албан хаагчид үндсэн цалингийн 20 хувиар тооцон сар бүр орон нутгийн нэмэгдлийг олгож байна.

2026 оны хувьд боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын хамтын хэлэлцээрийн дагуу эдгээр салбарын албан хаагчдын үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 15-50 хувиар нэмэгдүүлсэн. Мөн салбарын хамтын хэлэлцээрийн дагуу эдгээр салбарын албан хаагчдын үндсэн цалинг 2026 ондоо багтаан дахин 26-50 хувиар нэмэгдүүлэхээр байна. Өөрөөр хэлбэл, 2026 оны эцэст цэцэрлэгийн багшийн үндсэн цалин 1.4 сая төгрөгөөр нэмэгдэж 2.9 сая төгрөг, ЕБС-ийн багшийн үндсэн цалин 1.3 сая төгрөгөөр нэмэгдэж 2.8 сая төгрөгт хүрнэ.

Дээрх хамтын хэлэлцээрийн дагуу 2026 онд боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарын 127.0 мянган албан хаагчдын үндсэн цалин 50-89 хувиар нэмэгдэнэ.

000265003499

Ийнхүү зарим салбарыг онцгойлон авч үзэж цалин хөлсийг хэт өндөр хувиар нэмэгдүүлэх нь салбар хоорондын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх, зарим салбарт ажиллах хүчний дутагдал үүсэх, адил албан тушаалд ижил цалин хөлс олгох зарчмыг алдагдуулж байна. Түүнчлэн 2026 онд цалин хөлсийг нэмэгдүүлээгүй бусад салбар буюу төрийн тусгай, төрийн захиргаа, соёл, урлаг, спорт, төрийн мэргэжлийн болон төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын зүгээс цалин хөлсийг мөн адил нэмэгдүүлэх, зөрүүг арилгах арга хэмжээ авах талаар санал, хүсэлтийг ирүүлж байна.

Иймд салбарын хамтын хэлэлцээрийн хүрээнд эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалин 2026 онд 50-89 хувиар нэмэгдэхээр байгаа тул эдгээр салбарын албан хаагчдын үндсэн цалинг 2027 онд инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлж, үлдсэн буюу 2026 онд цалин хөлсийг нэмэгдүүлээгүй төрийн тусгай, төрийн захиргаа, соёл, урлаг, спорт, төрийн үйлчилгээний мэргэжлийн болон төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ